# ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
# ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2023 оны 05 сарын 23 өдөр Дугаар А/10 Арвайхээр сум

Улаанбурхан өвчнөөс урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээг эрчимжүүлэх тухай

Эрүүл мэндийн сайдын 2023 оны 05 дугаар сарын 22-ны өдрийн "Улаанбурхан өвчнөөс урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээг эрчимжүүлэх тухай" А/180 дугаар тушаалыг үндэслэн ТУШААХ нь:

1.Дархлаажуулалтын ээлжит 10 хоногийг "Улаанбурхан өвчнөөс хамтдаа сэргийлье" уриан дор 2023 оны 05 дугаар сарын 24-ний өдрөөс 06 дугаар сарын 05-ны өдрүүдэд зохион байгуулсугай.

2.Заавал хийх дархлаажуулалтын үндэсний товлолоос хоцорсон 15 хүртэлх насны хүүхдийг нөхөн дархлаажуулах ажлыг эрчимжүүлж, хамралтад тандалт, эргэмж судалгаа хийж, хариу арга хэмжээг зохион байгуулахыг Нийгмийн эрүүл мэндийн хэлтэс (М.Золзаяа), Хархорин сумын нэгдсэн эмнэлэг, сум, өрхийн эрүүл мэндийн төвийн дарга нарт тус тус үүрэг болгосугай.

3.Улаанбурхан, улаанууд өвчний эсрэг нэмэлт дархлаажуулалтын бэлтгэл ажлыг эхлүүлэх, үйл ажиллагааг зохион байгуулах нэгдсэн төлөвлөгөө хавсралтаар баталсугай.

4.Халдварт өвчний эрт сэрэмжлүүлэг, хариу арга хэмжээний тандалтын тогтолцоогоор мэдээлэгдэж байгаа цочмог халууралт цэврүүт болон толбон, гүвдрүүт тууралттай хамшинжийн тохиолдолд судалгаа хийж, лабораторийн шинжилгээгээр оношийг баталгаажуулан, 7 хоног бүрийн эргэн мэдээлэлд тусган мэдээлж хэвшихийг Нийгмийн эрүүл мэндийн хэлтэс (М.Золзаяа), Бүсийн оношилгоо эмчилгээний төв (Г.Дашжанцан), Хархорин сумын нэгдсэн эмнэлэг, сум, өрхийн эрүүл мэндийн төвийн дарга нарт тус тус үүрэг болгосугай.

5.Нэмэлт болон нөхөн дархлаажуулалтын ач холбогдол, эрсдэлийн харилцаа холбоог идэвхжүүлж, хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлах ажлыг эрчимжүүлэхийг Удирдлага, төлөвлөлтийн хэлтэс (Н.Оюунтуяа), Хархорин сумын нэгдсэн эмнэлэг, сум, өрхийн эрүүл мэндийн төвийн дарга нарт тус тус даалгасугай.

6.Өндөр тунт А аминдэмийг 5 хүртэлх насны хүүхдэд халдвар хамгааллын дэглэмийг баримтлан витаминжуулах ажлыг эхлүүлэхийг Эмнэлгийн тусламжийн хэлтэс (Ю.Ичинноров), Хархорин сумын нэгдсэн эмнэлэг, сум, өрхийн эрүүл мэндийн төвийн дарга нарт тус тус даалгасугай.

7.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт шинжилгээ, үнэлгээ, мэдээллийн хэлтэс (Я.Жаргал)-д даалгасугай.

622301057

ДАРГА Д.ШИВААННҮРДЭВ

Эрүүл мэндийн газрын даргын 2023 оны .05...
сарын 23...-ны өдрийн А/10 дугаар
тушаалын хавсралт

# УЛААНБУРХАН, УЛААНУУДЫН ЭСРЭГ НЭМЭЛТ ДАРХЛААЖУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЗОХИОН БАЙГУУЛАХ НЭГДСЭН ТӨЛӨВЛӨГӨӨ

| № | Үйл ажиллагаа | Хугацаа | Хариуцах эзэн | Хамтран ажиллах |
|---|---|---|---|---|
| | Нэг. Зохион байгуулалт, бүртгэл, судалгаа | | | |
| 1.1 | Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/528 дугаар тушаалаар батлагдсан “Халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх арга хэмжээний 2022-2025 оны төлөвлөгөө”-ний зорилт 2.3-т “Улаанбурхан өвчин зөөвөрлөгдөн орж ирэхээс сэргийлэх арга хэмжээ авах үйл ажиллагааны чиглэл”-ийг хэрэгжүүлэх зорилгоор Улаанбурхан, улаануудын эсрэг вакцинаар нэмэлт дархлаажуулалтыг 10 сараас 8 насны хүүхдүүдийг хамруулах асуудлыг орон нутгийн удирдлагуудад танилцуулж, хамтран ажиллах | 5 дугаар сарын 25-ны дотор | ЭМГ, НЭМХ | Хархорин сумын нэгдсэн эмнэлэг, Сум, өрхийн ЭМТ |
| 1.2 | Улаанбурхан, улаануудын эсрэг вакцинаар нэмэлт дархлаажуулалтыг орон нутагт зохион байгуулах шийдвэрийг гаргуулж, батлуулах | 5 дугаар сарын 29-ны дотор | ЭМГ, НЭМХ | Хархорин сумын нэгдсэн эмнэлэг, Сум, өрхийн ЭМТ |
| 1.3 | Вакциныг хүлээн авах, хадгалах, түгээх үеийн хүйтэн хэлхээний тоног төхөөрөмжийн бэлэн байдлыг хангаж улаанбурхан, улаануудын эсрэг вакцин, маркер, дагалдах хэрэгслийг татан авах | 5 дугаар сар | ЭМГ, НЭМХ | ХӨСҮТ |
| 1.4 | Нэмэлт дархлаажуулалтад хамрагдах 10 сартайгаас 8 насны хүүхдийн судалгааг | 5 дугаар сар | Хархорин сумын нэгдсэн эмнэлэг, Сум, өрхийн ЭМТ | ЭМГ, НЭМХ |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | нарийвчлан гаргаж, хамрагдвал зохих хүүхдийн тоог тодорхой болгох | | | |
| 1.5 | Улаанбурхан, улаануудын эсрэг вакцинаар нэмэлт дархдаажуулалтыг зохион байгуулах явуулын хөдөлгөөнт баг, дэмжлэгт хяналт хийх багийн бүрэлдэхүүнийг томилж, нарийвчилсан төлөвлөгөө боловсруулан батлуулах | 5 дугаар сар | Хархорин сумын нэгдсэн эмнэлэг, Сум, өрхийн ЭМТ | ЭМГ, НЭМХ |
| 1.6 | Сургуулийн өмнөх боловсролын байгууллага, ерөнхий боловсролын сургуулийн нэмэлт дархлаажуулалтад хамрагдах насны хүүхдийн судалгааг гаргах | 5 дугаар сарын 29-ны дотор | Хархорин сумын нэгдсэн эмнэлэг, Сум, өрхийн ЭМТ | ЭМГ, НЭМХ |
| 1.7 | Улаанбурхан, улаануудын эсрэг вакциныг батлагдсан хуваарийн дагуу сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдэд хүргүүлэх | 5 дугаар сар | Хархорин сумын нэгдсэн эмнэлэг, Сум, өрхийн ЭМТ | ЭМГ, НЭМХ |
| Хоёр. Нэмэлт дархлаажуулалтыг зохион байгуулахад оролцох эмч, мэргэжилтнүүдийг сургах | | | | |
| 2.1 | Нэмэлт дархлаажуулалтыг зохион байгуулах эмч, мэргэжилтнүүдийг ХӨСҮТ-өөс зохион байгуулах цахим сургалтад хамруулах | 5 дугаар сар | ЭМГ, НЭМХ | ХӨСҮТ |
| 2.2 | Нэмэлт дархлаажуулалт хийх эмч, вакцинатор сувилагч нарт нэмэлт дархлаажуулалт зохион байгуулах арга зүйн сургалт, уулзалтыг цахим болон танхимаар хийх | 5 дугаар сар | ЭМГ, НЭМХ | Хархорин сумын нэгдсэн эмнэлэг, Сум, өрхийн ЭМТ |
| 2.3 | Нэмэлт дархлаажуулалт хийх гарын авлагыг эмч, мэргэжилтнүүдэд хүргүүлж, арга зүйн сургалт дотооддоо зохион байгуулах | 5 дугаар сар | Хархорин сумын нэгдсэн эмнэлэг, Сум, өрхийн ЭМТ | ЭМГ, НЭМХ |
| 2.4 | Сургууль, цэцэрлэгүүдийн эмч, нийгмийн ажилтан нарт нэмэлт дархлаажуулалт зохион байгуулж, хамтран ажиллах талаар мэдээлэл хүргүүлэх | 5 дугаар сар | Хархорин сумын нэгдсэн эмнэлэг, Сум, өрхийн ЭМТ | ЭМГ, НЭМХ |
| Гурав. Дархлаажуулах үйл ажиллагаа | | | | |
| 3.1 | Төр, хувийн хэвшлийн цэцэрлэг, сургуулийн хүүхдийг улаанбурхан, улаануудын эсрэг вакцинаар дархлаажуулж, вакцин хийсэн тэмдэглэгээг зүүн гарын чигчий хуруун дээр хийх | 5-6 дугаар сар | Хархорин сумын нэгдсэн эмнэлэг, Сум, өрхийн ЭМТ | БШУГ, сургууль, цэцэрлэг |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 3.2 | Сургууль цэцэрлэгээр хамрагдаагүй хүүхдүүдийг байнгын цэг болон явуулын дархлаажуулалтаар вакцинжуулах ажлыг зохион байгуулах | 5-6 дугаар сар | Хархорин сумын нэгдсэн эмнэлэг, Сум, өрхийн ЭМТ | Сумдын ЗДТГ |
| 3.3 | Нэмэлт дархлаажуулалтын хамралт, дархлаажуулалтын дараа гарч болох урвал хүндрэлийн мэдээг дархлаажуулалтын нэгжээс өдөр бүр авах (хамрагдсан зорилтот бүлгийн хүн амын нэгдсэн бүртгэлийг дэлгэрэнгүй авах, мэдээллийн сан бүрдүүлэх) | 5-6 дугаар сар | Хархорин сумын нэгдсэн эмнэлэг, Сум, өрхийн ЭМТ | ЭМГ, НЭМХ |
| 3.4 | Нэмэлт дархлаажуулалт хамрагдсан хүүхдийн мэдээллийг цаасаар болон цахимд үнэн зөв оруулах | 5-6 дугаар сар | Хархорин сумын нэгдсэн эмнэлэг, Сум, өрхийн ЭМТ | ЭМГ, НЭМХ |
| Дөрөв. Мэдээлэл, сурталчилгаа | | | | |
| 4.1 | Улаанбурхан, улаануудын эсрэг вакцины нэмэлт дархлаажуулалтын нээлийн арга хэмжээг зарлах, хэвлэлийн бага хурал зохион байгуулах | 5 дугаар сарын 29-30 | ЭМГ, НЭМХ | Хархорин сумын нэгдсэн эмнэлэг, Сум, өрхийн ЭМТ |
| 4.2 | Нэмэлт дархлаажуулалтын талаар телевиз, радио, олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр өргөн сурталчлах | 5-6 дугаар сар | Хархорин сумын нэгдсэн эмнэлэг, Сум, өрхийн ЭМТ | ЭМГ, НЭМХ |
| 4.3 | Олон нийтийн мэдээллийн сүлжээг ашиглан нэмэлт дархлаажуулалтад хамрагдах тухай мэдээллийг зорилтот бүлэгт хүргэх | 5-6 дугаар сар | Хархорин сумын нэгдсэн эмнэлэг, Сум, өрхийн ЭМТ | ЭМГ, НЭМХ |
| Тав. Дэмжлэгт хяналт, хамралтын түргэвчилсэн үнэлгээ | | | | |
| 5.1 | Нэмэлт дархлаажуулаолтын явцад дэмжлэгт хяналт хийх, тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэхэд туслалцаа үзүүлэх | 5-6 дугаар сар | ЭМГ, НЭМХ | Хархорин сумын нэгдсэн эмнэлэг, Сум, өрхийн ЭМТ |
| 5.2 | Сонгогдсон газруудад дархлаажуулалт хэрхэн явагдсаныг хамралтын түргэвчилсэн үнэлгээгээр үнэлэх, шаардлагатай тохиолдолд нөхөн дархлаажуулах | 5-6 дугаар сар | ЭМГ, НЭМХ | Хархорин сумын нэгдсэн эмнэлэг, Сум, өрхийн ЭМТ |
| 5.3 | Нэмэлт дархлаажуулалтын үйл ажиллагааны нэгдсэн тайланг бичиж, холбогдох газруудад хүргүүлэх | 6 дугаар сар | ЭМГ, НЭМХ | Хархорин сумын нэгдсэн эмнэлэг, Сум, өрхийн ЭМТ |

-oOo-